



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/320

Мандалговь

Мал угаалгын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1, 21.4 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 01 тоот албан даалгавруудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал угаалгын ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, Мал угаалгын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Мал угаалгын суурин ваннуудыг засварлах, шинээр баригдсан ванны ашиглалтыг сайжруулж бүх бог малыг шумбуулж угаахыг сум, багийн Засаг дарга нар, мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай.

3. Мал угаалгын ажлыг технологит хугацаанд нь мэргэжил арга зүйгээр хангаж, зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (И.Жавхлант), захирамжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнахыг хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111100